

ДУНДГОВЬ АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН 2019 ОНЫ
СУРГУУЛИЙН ЖИЛИЙН ЭХНИЙ ХАГАС I ҮЕИЙН ТАЙЛАН

2019.05.30

Мандалговь хот

Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2018 оны А/437 дугаар “2019 оны сургуулийн жилд сургалт бэлтгэлийг зохион байгуулах тухай” тушаалын хавсралтаар батлагдсан Онцгой байдлын байгууллагын 2019 оны сургуулийн жилийн удирдамж болон Онцгой байдлын албаны сургалтын бодлого, бие бүрэлдэхүүний сургалт бэлтгэлийг зохион байгуулах ерөнхий журамд нийцүүлэн газрын даргын 2019 оны А/05 дугаар “Сургалт зохион байгуулах тухай” тушаалын 1 дүгээр хавсралтаар 2019 оны сургалтын төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг ханган ажилласан.

Офицер бүрэлдэхүүний мэргэжлийн ур чадвар дээшлүүлэх зорилгоор 32 удаа 68 цагийн хугацаатай гамшгийн төрөл тус бүрээр цагийн байдал дээр ажиллах дадлага сургуулийг зохион байгуулж, давхардсан тоогоор 416 офицерыг хамруулж мэдлэг чадварыг дээшлүүлсэн. Мөн Газрын даргын 2019 оны А/07 дугаар тушаалаар Монгол улсын Засгийн газрын 2018 оны 258 дугаар тогтоол, ОБЕГ-ын даргын 2019 оны 01/01 тоот албан даалгавар, 2019 онд дэвшүүлсэн зорилт болон гүйцэтгэлийн төлөвлөгөөг хэрэгжүүлж, алба хаагчдын албаны бэлэн байдлыг дээшлүүлэх зорилгоор “ОФИЦЕР БҮРЭЛДЭХҮҮНИЙ ЦУГЛАРАЛТ”-ыг зохион байгууллаа. Цуглралтаар холбогдох байгууллагаас хичээл заах багш нарыг урьж, “Байр зүйн зурагт ажиллах, төрийн болон албаны нууцын тухай, албан хэрэг хөтлөлт стандарт, албаны бэлтгэл бэлэн байдлыг дээшлүүлэх нь, мэдээллийн аюулгүй байдлыг хангах нь” сэдэвт 8 цагийн танхим, дадлага хосолсон сургалтыг зохион байгуулж алба хаагчдын мэдлэг ур чадварыг дээшлүүллээ.

Хууль эрх зүйн хичээлийг 64 удаа 128 цагийн хугацаатай зохион байгуулж алба хаагчдад “Гамшгаас хамгаалах тухай, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай, Цэргийн тэтгэвэр тэтгэмжийн тухай, Хөдөлмөрийн тухай, Галын аюулгүй байдлын тухай, Цэргийн албаны тухай, Цэргийн албан хаагчийн тэтгэвэр тэтгэмжийн тухай” зэрэг хуулиуд, Онцгой байдлын байгууллагад алба хаах журам, Онцгой байдлын байгууллагын алба хаагчид мэргэшлийн зэрэг, зэргийн нэмэгдэл

олгох журам, шалгуур үзүүлэлт, Онцгой байдлын байгууллагын алба хаагчид онцгой нөхцөлийн нэмэгдэл олгох журам, Онцгой байдлын байгууллагын алба хаагчид онцгой гавьяа байгуулсан тохиолдолд мөнгөн урамшуулал олгох журам"-ыг судлуулж, ярилцлага зохион байгуулсан. Мөн "Монгол Улсын Цэргийн нийтлэг дүрмүүд", Цэргийн дотоод албаны дүрэм, Цэргийн хүрээний ба харуулын албаны дүрэм, Цэргийн жагсаалын дүрэм, Цэргийн сахилгын дүрэм зэрэг нийтлэг дүрмүүдийг судалж, хэрэгжилтийг сайжруулах зорилгоор аймгийн Цэргийн штабтай хамтран алба хаагчдын "Цэргийн хэргийн мэдлэгийг дээшлүүлэх" 4 цагийн лекц, 2 цагийн дадлага сургалтыг зохион байгуулсан. Судалсан хичээлүүдээр боловсруулсан 26-30 асуулт бүхий тест авахад 68 алба хаагч хамрагдахаас шалгалтад 59 алба хаагч хамрагдсан. Энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэж байгаа 1, ДХИС-д сурч байгаа 3, өвчтэй 1, жирэмсний амралттай 3, ээлжийн амралттай, нийт 9 алба хаагч шалгалтанд хамрагдаагүй. А үнэлгээтэй 2, В үнэлгээтэй 42, С үнэлгээтэй 14, D үнэлгээтэй 1 тус тус дүгнэгдэж, амжилт 100, чанар 74 хувьтай.

Алба хаагчдын ажлын эрч хүч, үр бүтээлийг нэмэгдүүлэх, угийн бичиг хөтлөх анхан шатны мэдлэг олгох зорилгоор аймгийн Аудитын хэлтсийн дарга, Тэргүүлэх аудитор П.Төвсанаа, Монгол банкны хянан шалгагч Саранчимэг, төв номын сангийн сүлжээний инженер Ө.Ууганбаяр, Музейн арга зүйч С.Намжилмаа, ЭМНДХ-ийн байцаагч Баянмөнх, Лхагвасүрэн нарыг урьж "Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай ойлголт, Эдийн засгийн хөгжлийн тухай, Гэр бүлийн харилцаа, Өрхийн орлогыг зөв зарцуулах, Эрсдэлт зан үйлээс татгалзах, Угийн бичиг хөтлөх" сэдвүүдээр 6 цагийн лекц, 2 цагийн дадлагыг зохион байгууллаа. Сургалтад нийт 52 алба хаагч хамрагдсан. Сургалтын төгсгөлд алба хаагчдаас тус сургалтын талаар болон цаашид ямар сургалт хэрэгцээ шаардлага байгаа талаар санал асуулгын хуудас бөглүүлж, гарсан саналыг сургалтын төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж ажилласан.

Гал түймэр унтраах өдөр тутмын дасгал сургуулийг 1, 2, 3 дугаар схемээр байлдааны тархалт хийх, урьдчилан сунгасан 2 сунадаг шатаар гүйж сургалтын цамхгийн 3-р давхарт гарах, 2 сунадаг шатыг автомашинаас авч сургалтын цамхгийн 3 дугаар давхарт сунгаж гарах, араатай шатаар сургалтын цамхгийн 2, 4 дүгээр давхарт гарах, аврах олсоор эр, эм уяа зангидах, барилгын өндрөөс

нэрвэгдэгсдийг аврах, автомашиныг усан сан дээр байрлуулж ус соруулах зэрэг төрлүүдээр 660 удаа 1320 цагийн дадлагыг явуулж давхардсан тоогоор 4620 алба хаагчийг хамруулж, мэргэжлийн ур чадварыг дээшлүүж байна.

Хээрийн гаралт

Гамшгийн үеийн холбоог зохион байгуулах, алба хаагчдын ур чадварыг дээшлүүлж бэлтгэл бэлэн байдлыг хангах зорилгоор тус газрын шуурхай удирдлагын оператор, аврагч, жолооч-холбоочин нарын хээрийн гаралтыг зохион байгууллаа. Дадлага сургуулиар алба хаагч бүрийн хувийн бэлтгэл бэлэн байдлыг шалгаж, газарт ашиглагдаж байгаа богино болон хэт богино долгионы радио станцыг программчилж холбоонд орох, байршил тогтоогчоор өгөгдсөн цэгийг олох 6 цагийн дадлага, сургуулийг зохион байгуулсан. Тус газрын Эрдэнэдалай сум дахь Эрэн хайх, аврах салбарын 9 алба хаагчид сумын төвөөс 5 км-т аранзтай хээрийн гаралтыг зохион байгуулж, эмнэлгийн анхны тусламж үзүүлэх, онолын мэдлэг шалгах, хээрийн нөхцөлд хоол хийх зэрэг дадлага явуулсан.

Эрүүл мэнд

Алба хаагчдын сэтгэл зүйн бэлтгэл бэлэн байдлыг тогтвортой байлгах ажлын бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор “Эерэг хандлага, эрүүл хооллолт, дасгал хөдөлгөөн, анхны тусламж үзүүлэх мэдлэг чадвар” зэрэг сэдвүүдээр 6 цагийн лекц хичээлийг явуулж, “Гамшгийн үед үзүүлэх анхан шатны тусламж үйлчилгээ”, “Гэр бүлийн харилцаа, хүүхдийн хүмүүжил, хүүхдийн хүмүүжил, аврагч, гал сөнөөгчдийн сэтгэл санааны тогтвортой байдлыг хангах” зэрэг сэдэвт сургалтуудыг тус тус зохион байгуулж, давхардсан тоогоор 230 алба хаагчдыг хамруулсан. Тус аймгийн “Зооноз өвчин судлалын төв”-тэй хамтран “Зоонозын халдварын байгалийн голомт”, “Галзуу өвчин”, “Хачигт халдвараас урьдчилан сэргийлэх”, сэдэвт сургалтыг зохион байгуулж алба хаагчдын гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэх үед эрүүл мэндээ хамгаалах мэдлэгийг дээшлүүллээ. Аймгийн Улаан загалмайн хорооноос алба хаагчидтай “Онцгой байдлын газар улаан загалмайн хорооны хамтын ажиллагаа” сэдвээр уулзалт зохион байгуулж, өнгөрсөн онд хамтарч хэрэгжүүлсэн ажлын тайлан болон цаашид хийж хэрэгжүүлэх ажлыг танилцуулж, Монгол Улсад дутагдалтай байдаг цусны нөөцийг

нэмэгдүүлэх зорилгоор алба хаагчдын донорын тоог нэмэгдүүлсэн. Аймаг орон нутгаас зохион байгуулагдсан “Үрийг хүмүнжүүлэх”, “Гэр бүлийн харилцаа, Эрчүүдийн эрүүл мэнд, Гэр бүлийн үнэ цэнэ” сургалтуудад бүрэлдэхүүнийг хамруулсанаар алба хаагчдын биеэ зөв авч явах, бусадтай зөв харьцах, эрүүл мэндийн мэдлэгээ дээшлүүлэх ач холбогдолтой болсон.

Онцгой байдлын ерөнхий газрын дэд даргын өгсөн үүргийн дагуу Улсын нөөцийн салбарт мөрдөгдөж байгаа хууль, эрх зүйн баримт бичиг, үйл ажиллагааны үндсэн чиг үүргийг танилцуулах, хэрэгжилтийг хангуулах зорилгоор сургалт зохион байгуулах хөтөлбөр, төлөвлөгөөг гарган газрын даргаар батлуулж, Улсын нөөцийн салбар болон Говь-Угтаал, Эрдэнэдалай сумдын цэгийн ажилчдыг хамруулж сургалтыг зохион байгууллаа. Салбарын ажилчдад Цагдаагийн газар, Зэвсэгт хүчний 278 дугаар байгууламжийн мэргэжилтэн нарыг урьж, офицер бүрэлдэхүүн нийт 32 цагийн сургалтыг зохион байгуулсан. Заасан хичээлээр тест бэлдэж, нийт 9 ажилчдаас шалгалтыг авахад В үнэлгээтэй 5, С үнэлгээтэй 4 шалгагдсан.

Биеийн тамирын хичээлийг 7 хоногт 2 удаа нийт 32 удаа 64 цагийн сургалтад 1728 алба хаагчдын хамруулсан. Алба хаагчдаас “Бие бялдрын бэлтгэлжилтийн норматив”-ийн шалгалт авч, “Биеийн зохистой харьцаа”-г тодорхойлсон. Шалгалтанд нийт 70 алба хаагч хамрагдахаас жирэмсний амралттай -1, энхийг сахиулах ажиллагаанд-1, сургуульд сурч байгаа -3, ээлжийн амралттай -1 нийт 64 алба хаагч хамрагдлаа. Үүнээс: хэвийн жинтэй 51, 10кг-аас дээш илүү жинтэй -7, 1-9 кг илүү жинтэй – 6 алба хаагч ажиллаж байна. Энэ нь 2019 оны 05 дугаар сарын бие бялдрын стандартын үзүүлэлттэй харьцуулахад хэвийн жинтэй алба хаагч 15,7%-иар нэмэгдсэн, илүүдэл жинтэй алба хаагч 3,2%-иар буурсан үзүүлэлттэй байна. Илүү буюу биеийн зохистой харьцаа алдагдсан алба хаагчад хугацаат үүрэг өглөө.

Онцгой байдлын ерөнхий газраас зохион байгуулсан сургалт

Онцгой байдлын ерөнхий газраас зохион байгуулсан ангийн захирагч нарын сургалтад, ахлах дэслэгч Г.Шинэбат, Улсын нөөц, хүмүүнлэгийн тусламжийн ангийн захирагч, салбарын дарга нарын сургалтад, ахлах дэслэгч Ж.Цэцэгдэлгэр,

Гал түймрийн улсын хяналтын байцаагчийн эрх олгох сургалтад, ахмад Б.Баттулга, Онцгой байдлын байгууллагын мэргэжлийн аврагч-усчин, шумбагчийн дунд шатны сургалтад ахлах ахлагч Б.Баярцэмбэл, холбоо зарлан мэдээлэл хариуцсан мэргэжилтэн нарын сургалтад дэд ахлагч Н.Ганцацрал, Аврагч, нохой-хөтлөгчийн сургалтад ахлах ахлагч У.Баатархүү, төв орон нутгийн гал түймэр унтраах, аврах ангийн салааны захирагч, гал унтраах авто машины жолооч нарын сургалтад 8 алба хаагч, Эрэн хайх, аврах ажиллагааны удирдагч сургалтад бүлгийн дарга, аврах ажиллагааны зааварлагч, дэслэгч Г.Дэлгэрдалай, “Ажлын байран дахь хөдөлмөрийн аюулгүй байдал” сургалтад бүлгийн дарга аврах ажиллагааны зааварлагч, дэслэгч П.Батбаяр, дэслэгч Ч.Нацагдорж нарыг тус тус хамруулсанаар, алба хаагчдын мэргэжлийн ур чадвар, гамшгаас хамгаалах бэлтгэл бэлэн байдал дээшиллээ. Мөн Өмнөд бүсийн төв Өмнөговь аймгийн Онцгой байдлын газраас зохион байгуулсан цахим сургалтад салааны захирагч, жолооч нарын сургалтад 11 алба хаагч, шуурхай удирдлага, зарлан мэдээлэх төвд гамшиг осол, гал түймрийн дуудлагын мэдээг илтгэх хуудсаар авч нэгтгэн бүртгэлжүүлэх сургалтад 7 алба хаагчийг тус тус хамруулсан.

Дотоод хэргийн их сургуулийн Гамшиг судлалын магистрын хөтөлбөрт газрын орлогч, урьдчилан сэргийлэх тсагийн дарга-гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч, ахмад Ж.Оюунтамир, гал түймэр унтраах, аврах 25 дугаар ангийн салааны захирагч, дэслэгч Э.Блган, “Онцгой байдал- гамшгаас хамгаалах алба” мэргэжлийн эчнээ хөтөлбөрт ангиллын сургалт, урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан мэргэжилтэн, ахлах дэслэгч Б.Цэрэнням, нярав, ахлагч З.Оргилболд, хятад хэлний анхан шатны дамжаанд гал түймэр унтраах, аврах 25 дугаар ангийн аврагч-гал сөнөөгч, ахлах ахлагч З.Цэндсүрэн, Г.Буянбадрах, БХИС-ийн Холбооны мэргэжил олгох сургалтад шуурхай удирдлагын оператор, дэд ахлагч Ж.Нямсүрэн, “Мэргэшсэн нягтлан бодогч”-ийн сургалтад ахлах нягтлан бодогч, ахлах дэслэгч Б.Сайнзаяа, нягтлан бодогч Б.Төвшинжаргал, нарыг тус тус хамрууллаа.

Гадаад сургалт

Ёс зүйн хүмүүжил

"Сахилга хариуцлагын зөвлөгөөн"-ийг 2019 оны 01 дүгээр сарын 4-ны өдөр тус газрын сургалтын танхимд зохион байгуулж, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2019 оны 01 албан даалгаврыг танилцуулж, төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг офицер, ахлагч нарт үүрэг болгосон. Мөн ёс зүйн албаны гишүүд 2018 онд ёс зүйн албаны үйл ажиллагаа, 2019 онд хийгдэх ажлыг танилцуулж, санал солилцож **"Сахилгын зөрчилгүй хамт олон болъё"** уриалга гаргасан.

Монгол төрийн бичгийг дээдлэн дэлгэрүүлж иргэдэд сурталчлан таниулах үндэсний хэл бичгээрээ бахархах сурах идэвх сонирхлыг нэмэгдүүлэх "Үндэсний бичиг үсгийн баяр"-ын хүрээнд алба хаагчдын дунд Монгол бичгээр хэн зөв, цэвэр бичих вэ? Уралдааныг зохион байгуулж, "зөв, цэвэр бичигтэн"-г шалгаруулж, урамшуулсан. Дундговь аймгийн Засаг даргын тамгын газраас 2019 оныг бүтээн байгуулалт "Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил" болгон зарласантай холбогдуулан "Дундговь аймгийн ЗДТГ", "Дундговь аймгийн мисс эмэгтэйчүүд групп"-ээс хамтран эх хэлээ эрхэмлэн дээдлэх уриан дор зохион байгуулсан "Бүтээлч өрсөлдөөн хаягжуулах" уралдаанд амжилттай оролцож, тэргүүн байр эзэлж, 1 сая төгрөгөөр шагнуулсан.

Газрын алба хаагчдын гэр бүлд байгууллагын үйл ажиллагаа, албаны онцлогийг таниулах, гэр бүл, хамт олонд эерэг уур амьсгалыг бүрдүүлэх зорилгоор "Гэр бүлийн өдөрлөг" арга хэмжээг зохион байгуулсан. Арга хэмжээний хүрээнд "Үнэт зүйлсийн боловсролын академи"-ийн тэргүүн, гэр бүл судлаач Р.Мөнхцэцэгийг урьж "Гэр бүлийн үнэт зүйл" сэдвээр 2 цагийн лекц явуулж, байлдааны хувцас өмсөх, хоолой дэлгэх, авхаалж самбаа сорьсон хөгжөөнт тэмцээнийг тус тус зохион байгуулж, 1, 2 дугаар байрыг шагнаж, урамшуулсан.

Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан иргэдэд Авлигатай тэмцэх Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, Авлигатай тэмцэх газрын хуулиар хүлээсэн чиг үүрэг, үйл ажиллагааг танилцуулах, авлигаас урьдчилан сэргийлэх, иргэдийн дуу хоолойг сонсох зорилгоор "Иргэн төвтэй соён гэгээрүүлэх өдөрлөг"-т бүрэлдэхүүнийг бүрэн хамруулсан.

Гал түймэртэй тэмцэх байгууллага үүсэн байгуулагдсаны 97 жилийн ойн арга хэмжээний хүрээнд газрын ахмадын зөвлөлөөс зохион байгуулж буй 3 төрөлт тэмцээнийг амжилттай зохион байгуулсан. Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчний 98 жилийн ойн баярыг угтаж тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын дунд зохион байгуулагдсан спорт тэмцээнд амжилттай оролцож гар бөмбөгийн төрөлд эрэгтэй эмэгтэй мөнгөн медаль, сагсан бөмбөг төрөлд эрэгтэй алтан медаль, олс таталт төрөлд хүрэл медаль, ширээний теннис төрөлд эрэгтэй эмэгтэй хүрэл медаль тус тус хүртэж, багийн дүнгээр “Дэд” байр эзэлсэн. Газрын Эмэгтэйчүүдийн зөвлөлөөс тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагын эмэгтэйчүүдийн дунд “Спортоор нөхөрлөө 2019” гар бөмбөгийн тэмцээнийг амжилттай зохион байгууллаа.

Онцгой байдлын байгууллагын 2019 оны спортын аварга шалгаруулах тэмцээнд тус газраас 5 тамирчид оролцож, бие бялдрын ерөнхий хөгжлийн дасгал, олс таталт, гар болон хөл бөмбөг гэсэн спортын төрлүүдээр өрсөлдөж Өмнөд бүсийн баг тамирчид нэгдүгээр байр эзэлсэн.

Алба хаагчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, хамтын ажиллагааг сайжруулж спортоор хичээллэх идэвхийг нэмэгдүүлэх зорилгоор Онцгой байдлын газрын “Ахлагчдын зөвлөл”-өөс санаачлан “Мөсний баяр 2019” арга хэмжээг зохион байгуулж, 43 алба хаагчдыг хамруулсан.

Монгол түмний уламжлалт сар шинийн баярыг тохиолдуулан сайн үйлсийн аяныг өрнүүлж 3 өрхөд баярт шаардлагатай хэрэгцээт зүйлсээр, "Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах" өдрийг тохиолдуулан "Халуун сэтгэл" сайн үйлсийн аян өрнүүлж өрх толгойлсон эмэгтэйчүүдэд сэтгэлийн бэлэг барилаа. Мөн “Цагаан сар” нэгдсэн арга хэмжээний хүрээнд БЗӨБүсийн цахилгаан түгээх салбар сүлжээтэй хамтран галын аюулаас урьдчилан сэргийлэх үзлэг шалгалтыг зохион байгуулж 1 өрхийн цахилгааны монтажиг стандартын шаардлагад нийцсэн материалаар мэргэжлийн төвшинд хийж хүлээлгэн өгсөн.

Алба хаагчдын дунд “Хөгжөөнт буухиа” тэмцээнийг 8 төрлөөр зохион байгуулж, авхаалж самбаагаа сорьж нийлбэр дүнгээр ахлах ахлагч Д.Батзаяа

ахлагчтай баг тэргүүн байр эзэлж, дэслэгч П.Батбаяр ахлагчтай баг 2 дугаар байранд орсон.

Монгол үндэсний ёс заншил, өв соёлыг түгээн дэлгэрүүлэх, өвлүүлэх, сурталчлах, түүгээрээ бахархах, хамт олны чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор “Бэсрэг наадам 2019”-ыг зохион байгууллаа. Тус наадмын хүрээнд алба хаагчдын дунд Хүчит бөхийн барилдаан, шагайн наадгай, дэмбээний баяр зэрэг монгол уламжлал, ёс заншлыг харуулсан тэмцээн уралдаануудыг тус тус зохион байгуулсан.